

**БАЯНГОВЬ СУМЫН 2024 ОНЫ БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ
ФОТО МОНИТОРИНГИЙН АРГААР ҮНЭЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**



2024 оны 09 дугаар сарын 06 өдөр

АГУУЛГА

Нэг. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА:.....	4-5
Хоёр. БЭЛЧЭЭРИЙН МОНИТОРИНГИЙН ТАЛААР ХИЙГДСЭН АЖИЛ	5
2.1. Мониторингийн цэг байгуулах, байрлыг сонгосон үндэслэл.....	5
2.2. Мониторингийн шалгуур үзүүлэлт.....	5
Гурав. БЭЛЧЭЭРИЙН МОНИТОРИНГИЙН МЭДЭЭЛЛИЙН САН.....	6
3.1. Веб системд бэлчээрийн мониторингийн мэдээллийг оруулсан байдал.....	6
Дөрөв. БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТ.....	7-13
4.1. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт.....	7-9
4.2. Бэлчээрийн газрын фотомониторингийн цэг.....	9-10
4.3. Байгалийн бүс, бүслүүр.....	10
4.4. Бэлчээрийн газрын өөрчлөлт, төлөв байдал.....	10
4.5. Сэргэх чадавхи ба нөхөн сэргээх зөвлөмж.....	11
4.6. Бэлчээрийн даац.....	12
4.7 Бэлчээр ашиглагчдын хэсэг /БАХ/.....	12-13
Тав. БЭЛЧЭЭРИЙН ХӨРС ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ.....	13
Зургаа. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ.....	14


Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Мониторингийн мэдээлэл оруулах.....	6
Хүснэгт 2. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт.....	7-8
Хүснэгт 3. Хөдөө аж ахуйн газарт гарсан өөрчлөлт.....	9
Хүснэгт 4. Бэлчээрийн мониторингийн цэгийн төлөөлж буй талбайн хэмжээ.....	9
Хүснэгт 5. Бэлчээрийн фото мониторингийн цэгийн тоо.....	10
Хүснэгт 6. Бэлчээрийн мониторингийн цэгийг байгалийн бүс бүслүүрээр гаргасан байдал.....	10
Хүснэгт 7. Бэлчээрийн 2024 оны сэргэх чадавхийн байдал, талбай га-аар.....	10
Хүснэгт 8. Бэлчээрийн сэргэх чадавхийн ангилал.....	11
Хүснэгт9. Баянговь сумын бэлчээрийн сэргэх чадавхийн ангиллыг харьцуулсан хувь.....	12
Хүснэгт 10. Бэлчээрийн даац.....	12
Хүснэгт 11. БАХ буюу бэлчээр ашиглагчдын хэсэг.....	13
Хүснэгт 12. Хөрс хамгаалах, нөхөн сэргээлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажил...	13

Нэг. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

1.1 Физик газар зүйн онцлог

Баянхонгор аймгийн Баянговь сум нь аймгийнхаа өмнөт хэсэгт оршиж баруун хойд талаараа Баянцагаан, хойт талаараа Баян-Овоо, зүүн хойт талаараа Баянлиг, зүүн хойд талаараа Богд, урд талаараа Өмнөговь аймаг, баруун урд талаараа Баян-Өндөр сумын нутаг дэвсгэртэй тус тус хиллэнэ. Баянговь сумын нутаг дэвсгэр нь монгол орны физик газар зүйн мужлалаар Алтайн уулархаг их мужийн дэд муж болох Говь-Алтайн нурууны салбар уулсын бүсэд багтана. Газрын гадарга нь говийн шинж төрхийг хадгалах бөгөөд алдарт Аж Богд уулын өврөөр урсах Хургалж голын тохой, Хэлтгий булагийн хөлд тариалангийн гол газрууд байрлана. Эдгээр талбайнууд нь сумын төвийнхээ баруун талаар орших бөгөөд тэгшивтэр гадаргатай.



Баянговь сумын хойд цэг нь Жинст, Богд, Баянговь сумуудын хилийн уулзвар цэг болох далайн түвшинээс дээш 3957 метр өргөгдсөн Их Богд уулын ноён оргил. Хатгийн урд цэг Шинэжинст, Баянлиг, Өмнөговь аймгийн Гурван тэс сумын уулзвар болох түвшингээс дээш 1185 метр өргөгдсөн Гурилын ус.

Сумын нутаг бэлчээр бүхэлдээ цөлийн, цөлөрхүү хээрийн бүсэд багтдаг боловч өндөр уул, тал хээр, говь цөлийн гэж ангилахуйц өвөрмөц тогтоц байршилтай. Энэ нь хөрсний бүтэц, бэлчээрт ургадаг ургамлын төрөл, зүйл, бүтэц, идээшиж нутагшсан ан амьтны төрөл зэргээс тодорхой байна.

Тус сумд 200-аад зүйл дээд ургамал ургадаг бөгөөд Морин зээргэнэ, арц зэрэг монголын улаан номонд орсон ховор тархацтай ургамлаас гадна Монгол бүйлс, Говийн харгана, Хэвэрэг хавчит ортууз зэрэг зөвхөн монголд ургадаг хэд хэдэн төрөл, зүйл ургамал мөн эмийн болон хүнсний түгээмэл ач холбогдолтой 50 гаруй төрлийн ургамлууд ургадаг байна. Сумын цаг уурын онцлогыг авч үзвэл нутаг дэвсгэр нь арай өндөрлөг уулархаг бүсэнд орших тул эх газрын эрс тэс уур амьсгал зонхилдог.

Энэ нь хоногийн болон улирлын агаарын температурын хэлбэлзэл ихтэй, жилийн хур тунадасны хувиарлалт харилцан адилгүй, агаарын хуурайшилт ихтэй, нилээд урт хүйтэн өвөл болдог зэргээр тайлбарлагдана.

Олон жилийн дундажаар жилийн агаарын дундаж температур $+3,8^{\circ}$ ба дулааны улиралд буюу IY-X саруудад сарын дундаж температур $+14,4^{\circ}$ хүрдэг. Жилийн хур тунадасны нийлбэр 108.2 мм ба түүний ихэнх нь IY-X саруудад хур борооны хэлбэрээр унаж дундажаар 102.0 мм хүрдэг байна.

Эндээс харахад тус сумын хувьд ХАА-н таримлын болцонд агаарын температур хүрэлцээтэй бөгөөд чийгийн хангамж сайтай тохиолдолд арвин ургац авах боломж бий.

Олон жилийн дундажаар жилд 60-80 мм орчим хур тундас ордог, хур тундасны хувиарлалт жигд биш жилд орох тундасны 75-80 хувь нь 5-9 дүгээр сард ордог, хөндий нам дор газраасаа өндөр уулын бүсэд тунадас ахиу ордог.

Засаг захиргааны зохион байгуулалтын хувьд 5 багт хуваагдах бөгөөд сумын төв Өргөн нь Баянхонгор аймгаас 230 км зайтай оршино.

Хоёр. БЭЛЧЭЭРИЙН МОНИТОРИНГИЙН ТАЛААР ХИЙГДСЭН АЖИЛ

2.1. Мониторингийн цэг байгуулах, байрлыг сонгосон үндэслэл

Баянговь сумын хэмжээнд 17 цэг байгуулсан бөгөөд тухайн сумын нийт бэлчээрийг улирал бүрээр төлөөлж чадахуйц цэгүүдийг сонгосон. 2021 онд давхардсан буюу шаардлага хангахгүй байсан 3 цэгүүдийг хасаж Газрын кадастрын мэдээллийн санд оруулан ажилласан. 2024 онд сумын цэгийн тоо өөрчлөлт гараагүй байна.

2.2. Мониторингийн шалгуур үзүүлэлт

Баянговь сум нь 2015 оноос эхлэн бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлж байгаа бөгөөд жил бүр мониторингийн цэгийн тоог нэмэгдүүлж ирсэн.

Баянговь сумын бэлчээрийн фото мониторингийн цэг

№	Сумын нэр	Байгуулсан цэгийн тоо									
		2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Баянговь	10	10	18	19	19	20	17	17	17	17
	Нийт дүн	10	10	18	19	19	20	17	17	17	17

Гурав. БЭЛЧЭЭРИЙН МОНИТОРИНГИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

3.1. Веб системд бэлчээрийн мониторингийн мэдээллийг оруулсан байдал.

Хүснэгт 1. Мониторингийн мэдээлэл оруулах

№	Сумын нэр	Фотомониторингийн цэгийн тоо	2024 онд						
			Координат	Бүрхэц	Биомасс	Срэгхэ чадавхи	Зураг	Малын тоо	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Баянговь	17	17	17	17	17	17	17	100
нийт дүн		17	17	17	17	17	17	17	100

064 Баянговь 06410 Баянговь

Бэлчээрийн мэдээлэл

Жагсаалт

№	Цэгийн нэр	Газрын нэр	Газрын тэдэргийн хэлбэр	Бүртгэсэн өнөө	Хялбар
1	06410019	Тэжээл	11. Хайрга-чулуурхай хөрстэй нам уулс, толгодын Заримдаг сөөгөнд өдлөг хялганат цэлийн хээрийн бэлчээр	2019-09-06	✓
2	06410015	Хайрга-чулуурхай	17. Хайрга-чулуурхай тал газрын Заримдаг сөөгөнд өдлөг хялганат цэлийн бэлчээр	2018-04-02	✓
3	06410016	Наран-хуурай	11. Хайрга-чулуурхай хөрстэй нам уулс, толгодын Заримдаг сөөгөнд өдлөг хялганат цэлийн хээрийн бэлчээр	2018-04-02	✓
4	06410005	Бид хуурай өмнө	17. Хайрга-чулуурхай тал газрын Заримдаг сөөгөнд өдлөг хялганат цэлийн бэлчээр	2018-04-02	✓
5	06410006	Цандан-хуурай өмнө	13. Мараалаг шаварлаг хөрстэй тал газрын Таана-Заримдаг сөөгөнд өдлөг хялганат цэлийн хээрийн бэлчээр	2018-04-02	✓
6	06410007	Бид хуурай талтай хуурай	13. Мараалаг шаварлаг хөрстэй тал газрын Таана-Заримдаг сөөгөнд өдлөг хялганат цэлийн хээрийн бэлчээр	2018-04-02	✓
7	06410016	Талын хуурай хуурай	17. Хайрга-чулуурхай тал газрын Заримдаг сөөгөнд өдлөг хялганат цэлийн бэлчээр	2018-04-02	✓
8	06410005	Бид хуурай өмнө	6. Чулуурхай хөрстэй уул, толгодын орой болон энгэр хайгуурын Чулуусал агал өвс-ниймэг дэнхүүт утган-арь-говын хялганат бэлчээр	2018-04-02	✓
9	06410001	Талын хуурай өмнө	11. Хайрга-чулуурхай хөрстэй нам уулс, толгодын Заримдаг сөөгөнд өдлөг хялганат цэлийн хээрийн бэлчээр	2018-04-02	✓
10	06410011	Шарын өмнө хуурай	14. Хуурай, мараалаг хөрстэй хөлс, нам дун газрын Шар, улаан будагтана-дрост цэцгийн бэлчээр	2018-04-02	✓

1 - 10 / 17



Баянговь сумын бэлчээрийн 2024 оны фотомониторингийн ажлын тайлан

Дөрөв. БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТ

4.1. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт

Сумын нийт газар нутгийн хэмжээ 466159 га, үүнээс бэлчээрийн талбай 455987.7276 га, үүнээс өвөл, хаврын бэлчээр 241622.8105 га, зун намрын бэлчээр 214364.9176 га, газар тариаланд тохиромжтой талбай 93.7624 га. Баянговь сум нь 2023 оны жилийн эцсийн байдлаар газрын нэгдмэл санд Хөдөө аж ахуйн газар 456141.489 га буюу 97.85 %, Хот, тосгон, бусад суурины газар 3160.931 га буюу 0.68%, зам, шугам сүлжээний газар 514.08 га буюу 0.11%, Ойн сан бүхий газар 6282.5 га буюу 1.35%, Усны сан бүхий газар 60 га буюу 0.01%, хувийг тус тус эзэлж байна.

График 1. Газрын нэгдмэл сангийн ангилалыг сумын нийт газар нутагт харьцуулсан хувь



Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд гарсан өөрчлөлт

Хүснэгт 2. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт

Д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал		2022 он	2023 он	Зөрүү
1	2	3	4	5	6
1	Нийт газар		466159.0	466159.0	0
2	Хөдөө аж ахуйн газар	Бүгд	456141.489	456141.489	0
3		Бэлчээр	455987.8672	455987.7276	-0.14
4		Хадлан	20	20	0
5		Усалгаатай тариалан	93.7624	93.7624	0
6		Усалгаагүй тариалан	0	0	0
7		Атаршсан газар	0	0	0
8		Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар	39.8585	39.9985	0.14
9		Ашиглахад тохиромжгүй газар	0	0	0

10	Хот тосгон бусад суурины газар	Бүгд		10	3160.9315	3160.9315	
11		Үүнээс	Барилга байгууламжийн дэвсгэр газар	11	12.7839	12.7839	0
12			Сууршлын газар	12	30.2158	31.0855	0.8697
13			Үйлдвэрийн газар	13	1	1	0
14			Нийтийн эдэлбэрийн газар	14	183.8632	182.9935	-0.8697
15			Амралт, аялал жуулчлалын газар	15	1.9986	1.9986	0
16			Уурхайн газар	16	2931.07	2931.07	0
17			Хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн барилга байгууламжийн газар	17	0	0	0
18			Хот суурин доторх инженерийн дэд бүтцийн зориулалтын газар	18	0	0	0
19			Цаашид тэлж хөгжих нөөц газар	19	0	0	0
20	Зам шугам сүлжээний газар	Бүгд		20	514.08	514.08	0
21		Үүнээс	Төмөр замын газар	21	0	0	0
22			Автозамын газар	22	500.05	500.05	0
23			Агаарын тээврийн газар	23	0	0	0
24			Шугам, сүлжээний газар	24	14.03	14.03	0
25			Усан тээврийн газар	25	0	0	0
26	Ойн сан бүхий газар	Бүгд		26	6282.5	6282.5	0
27		Үүнээс	Ойн сан бүхий газар	27	6282.5	6282.5	0
28			Ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй газар	28	0	0	0
29	Усан сан бүхий газар	Бүгд		29	60	60	0
30		Үүнээс	Мөрөн гол, горхи, булаг, шандны эзлэх газар	30	0	0	0
31			Усны сан бүхий газар	31	0	0	0
32			Булаг, шанд	32	36	36	0
33			Нуур, цөөрөм, тойром	33	24	24	0
34			Мөнх цас, мөсөн гол	34	0	0	0
35			Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс	35	0	0	0

❖ Хөдөө аж ахуйн газар

Тайлант онд хөдөө аж ахуйн газар нийт 456141.489 га талбайгаар тусгагдсанаас бэлчээрийн газар 455987.7276 га, усалгаатай тариалангийн газар 93.7624 га, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар 39.9985 га газрыг тус тус эзэлж байна.

Хүснэгт 3. Хөдөө аж ахуйн газарт гарсан өөрчлөлт

Газрын нэгдмэл сангийн ангилал		2022 он	2023 он	Зөрүү
Хөдөө аж ахуйн газар	Бэлчээр	455987.8672	455987.7276	-0.14
	Хадлан	20	20	0
	Усалгаатай тариалан	93.7624	93.7624	0
	Усалгаагүй тариалан	0	0	0

	Атаршсан газар	0	0	0
	Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар	39.8585	39.9985	0.14
	Ашиглахад тохиромжгүй газар	0	0	0
	Хөдөө аж ахуйн нийт газар	456141.489	456141.489	

❖ Бэлчээрийн газар

Бэлчээрийн газарт 455987.7276 га газар байгаагаас Өвөл-хаврын бэлчээрт 241622.95 га газраас ХАА-н барилга, байгууламжийн газар 0.14 га хасагдаж 241622.81 га болж өөрчлөгдсөн. Зун-намрын бэлчээрт 214364.9176 га байна.

Ангилал	Бэлчээрийн газраас хасагдаж бусад ангилал руу шилжсэн байдал	Бусад ангиллаас хасагдаж бэлчээрийн газарт шилжсэн байдал
1	2	3
Хөдөө аж ахуйн газар /га/		
Тариалангийн газар	-	
Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар	0.14	
Хот тосгон бусад суурины газар /га/		
Барилга байгууламжийн дэвсгэр газар	-	
Нийтийн эдэлбэр газар	-	
Үйлдвэрийн газар	-	
Уурхайн газар	-	
Гэр хорооллын газар	-	
Зам шугам сүлжээний газар /га/		
Шугам, сүлжээний газар	-	
Ойн сан бүхий газар	-	

4.2. Бэлчээрийн газрын фотомониторингийн цэг

Хүснэгт 4. Бэлчээрийн мониторингийн цэгийн төлөвлөж буй талбайн хэмжээ

№	Аймаг	Сумын нэр	БАХ-ийн тоо	Мониторингийн цэгийн тоо	Төлөөлж буй талбайн хэмжээ /га/
1	2	3	4	5	6
1	Баянхонгор	Баянговь	4	17	386547.85
Нийт			4	17	386547.85

Хүснэгт 5. Бэлчээрийн фото мониторингийн цэгийн тоо

№	Сумын нэр	Байгуулсан цэгийн тоо									
		2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Баянговь	10	10	18	19	19	20	17	17	17	17
	Нийт дүн	10	10	18	19	19	20	17	17	17	17

Баянговь сумын бэлчээрийн 2024 оны фотомониторингийн ажлын тайлан

Сумын хэмжээнд БАХ-ийн улирлын бэлчээрийг төлөөлөхүйц БАХ тус бүрт 1-3 хүртэлх мониторингийн цэгүүд байдаг.

4.3. Байгалийн бүс, бүслүүр

Баянговь сум нь байгалийн бүс, бүслүүр хувьд газар нутаг нь цөлөрхөг хээрийн бүс, цөлийн бүсэд хамаардаг. Сумын бэлчээрийн фото мониторингийн нийт цэгийн 9 цэг нь цөлөрхөг хээрийн бүсэд, 7 цэг нь цөлийн бүс, 1 цэг нь хуурай хээрийн бүсэд багтаж байна.

Хүснэгт 6. Бэлчээрийн мониторингийн цэгийг байгалийн бүс бүслүүрээр гаргасан байдал.

№	Сум	Байгалийн бүс бүслүүр	Мониторинг цэгийн тоо	Төлөөлөх талбайн хэмжээ /га/
1	2	3	4	5
1	Баянговь	Цөлөрхөг хээрийн бүс	9	177678.27
		Цөлийн бүс	7	194081.49
		Хуурай хээрийн бүс	1	14788.09
Нийт дүн			17	386547.85

4.4. Бэлчээрийн газрын өөрчлөлт, төлөв байдал

Хүснэгт 7. Бэлчээрийн 2024 оны сэргэх чадавхийн байдал, талбай га-аар

№	Аймаг	Сумын нэр	Байгалын бүс бүслүүрийн нэр	Мониторингийн цэгийн тоо	Бэлчээрийн сэргэх чадавхийн ангилал /1-5 ангилал/			Нийт талбайн хэмжээ /га/
					Цэгийн ангилал	Мониторингийн цэгийн тоо	Төлөвлөж буй талбайн хэмжээ /га/	
1	2	3	4	5	6	7	8	9
1	Баянхонгор	Баянговь	Хуурай хээрийн бүс, Цөлөрхөг хээрийн бүс, цөлийн бүс	17	I	1	6988.15	386547.85
					II	10	225113.14	
					III	6	154446.56	
Нийт				17		17		

4.5. Сэргэх чадавхи ба нөхөн сэргээх зөвлөмж

Бэлчээр ашиглалтын эрчим, тэжээлийн нөөцийн бүрдэлт, тэжээл зарцуулалт, мал аж ахуйн бүтээмжийн тогтвортой байдал, түүнчлэн хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, усны ай савын экосистемийн тогтвортой байдлыг хангахад бэлчээрийн сэргэх чадавхид суурилсан ашиглалтын үндсэн зарчим болох боломжит даацыг баримтлах нь чухал юм.

Хүснэгт 8. Бэлчээрийн сэргэх чадавхи ба нөхөн сэргээх зөвлөмж

№	Сумын нэр	Мониторингийн цэгийн тоо	Нийт талбай	2023 он									
				Цэгийн тоо	I-д хамрагдах талбай, га	Цэгийн тоо	II-д хамрагдах талбай, га	Цэгийн тоо	III-д хамрагдах талбай, га	Цэгийн тоо	IV-д хамрагдах талбай, га	Цэгийн тоо	V-д хамрагдах талбай, га
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Баянговь	17	386547.85	1	54155.05	14	232081.29	2	100311.51	0		0	
Нийт		17	386547.85	1	54155.05	14	232081.29	2	100311.51	0		0	

№	Сумын нэр	Мониторингийн цэгийн тоо	Нийт талбай	2024 он									
				Цэгийн тоо	I-д хамрагдах талбай, га	Цэгийн тоо	II-д хамрагдах талбай, га	Цэгийн тоо	III-д хамрагдах талбай, га	Цэгийн тоо	IV-д хамрагдах талбай, га	Цэгийн тоо	V-д хамрагдах талбай, га
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Баянговь	17	386547.85	1	6988.15	10	225113.14	6	154446.56	0		0	
Нийт		17	386547.85	1	6988.15	10	225113.14	6	154446.56	0		0	

Сэргэх чадавхийн I-р түвшин:Байгалийн унаган төлөв байдлаа алдаагүй. Бүтээмжийн хувьд бага зэргийн өөрчлөгдсөн нь 1-3 жилийн ургалтын хугацаанд сэргэнэ.

Сэргэх чадавхийн II-р түвшин:Байгалийн унаган төлөв байдлаас өөрчлөгдөж бага зэрэг доройтсон. Ашиглалтын горим, ачааллыг тохируулснаар харьцангуй богино хугацаанд (3-5 жилийн ургалтын хугацаанд) сэргэнэ.

Сэргэх чадавхийн III-р түвшин:Бэлчээрийн ургамлын бүтэц бүрэлдхүүн болоод бүтээмжийн хувьд нэлээд өөрчлөгдөж доройтсон. Экосистемийн үйлчлэлүүд нэлээд алдагдсан. Ашиглалтыг зөв зохион байгуулснаар сэргэх боломжтой, дунджаар 5-10 жил шаардагдана.

Хүснэгт 9. Баянговь сумын бэлчээрийн сэргэх чадавхийн ангилалыг харьцуулсан хувь.

№	Бэлчээрийн сэргэх чадавхын ангилал	2020 он /%/	2021 он /%/	2022 он /%/	2023 он /%/	2024 он /%/
1	2	3	4	5	6	7
1	I-Байгалийн унаган төрхөө алдаагүй		66.8	3.6	5.88	5.88
2	II-бага зэрэг доройтсон	94.9	33.1	69.595	82.35	58.82
3	III-дунд зэрэг доройтсон			26.805	11.76	35.29
4	IV-хүчтэй доройтсон	5.1				
5	V-Маш хүчтэй доройтсон					
	Нийт хувь	100	100	100	100	100

4.6. Бэлчээрийн даац

Хүснэгт 10. Бэлчээрийн даац.

№	Сумын нэр	Тэжээлийн нөөц, тн	Хонины идэх өвс, кг	Өвөл, хаврын бэлчээрийн даац, хонин толгой	Малын тоо хонин толгой, 2023 он	Зөрүү
1	2	3	4	5	6	7
1	Баянговь	31455498.8	210	149788.0895	229334.6	-79546.5105
	Нийт	31455498.8	210	149788.0895	229334.6	-79546.5105

Сумын хэмжээнд нийт мал бэлчээрлэх талбай 455987.7276 га, 2023 оны байдлаар 229334.6 хонин толгой мал байгаа бөгөөд 149788.0895 хонин толгой малд бэлчээр хүрэлцээтэй, бэлчээрийн газрыг өөрчлөлтийг 2023 оны тайлантай харьцуулахад бэлчээрийн сэргэх чадавхи сумын хэмжээнд буурсан байна. Энэ нь зундаа хур тунадас бага, бэлчээрийн ургамлын ургац дунд зэрэг байна.

4.7. Бэлчээр ашиглагчдын хэсэг /БАХ/

Хүснэгт 11. Бэлчээр ашиглагчдын хэсэг /БАХ/

№	Сумын нэр	Мониторингийн цэгийн тоо	Бэлчээр ашиглагчдын хэсэг				
			БАХ-т хамрагдах цэгийн тоо	БАХ-ын тоо	БАХ-тай байгуулсан гэрээний тоо	БАХ-д байгаа өрхийн тоо	БАХ-ийн талбай /га-аар/
1	2	3	4	5	6	7	8
1	Баянговь	17	17	4	4	720	386547.85
Нийт		17	17	4	4	720	386547.85

Тав. БЭЛЧЭЭРИЙН ХӨРС ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Хүснэгт 12. Хөрс хамгаалах, нөхөн сэргээлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажил

№	Сумын нэр	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа \га\					
		Бэлчээр чөлөөлсөн	Булгийн эх хамгаалж, хаших	Бэлчээр усжуулсан	Бэлчээр өнжөөж сэлгэсэн	Бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх	Худаг гаргах
1	2	3	4	5	6	7	8
1	Баянговь	-	-	-	-	-	1
Нийт							1

Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгө, санхүүжилтаар Цоохор 4-р багт Тоором гэх газарт шинээр 1 худаг бий болгосон.

Зургаа. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ

Бэлчээрийн чанарыг доройтуулахгүйн тулд хамгийн гол нь малын тоог бэлчээрийн даацад нь тохируулж малын тоо бус малын чанарт анхаарах нь туйлын чухал. Мөн хур чийг багатай, ургамлын сэргэлт удаантай энэ нөхцөлд ялангуяа гантай жилүүдэд нэг бэлчээр урт хугацаагаар давтуулж ашиглахгүй, ашиглалтаас чөлөөлөн сэргээж бага ачааллаар ашиглах шаардлагатай байна.

Цаашид бэлчээрийг хэт ачаалалд оруулж доройтохоос сэргийлж улирлын хуваарьтай ашиглах хугацааг чанд баримтлах, даацад тохируулсан мал бэлчээх юм.

Мөн бэлчээрийн газрыг чөлөөлөх, доройтсон бэлчээрийг өнжөөж сэлгэх хуваарь гаргах, хортон мэрэгчдийг устгах, бэлчээрийг усжуулах зэрэг арга хэмжээг жил бүр

сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган сум, орон нутгаас дээрх арга хэмжээнд тодорхой хөрөнгө тавьж ажиллах шаардлагатай байна.

ХЯНАСАН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ТАЙЛАН БИЧСЭН
ГАЗРЫН ДААМАЛ



Д.ОТГОНЖАРГАЛ

Б.МААСҮРЭН